



**БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ**

ДЭЭД БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 2020/2021



ДЭЭД БОЛОВСРОЛ

**УЛААНБААТАР ХОТ
2021 ОН**

АГУУЛГА

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА	5
1. Дээд боловсролын сургалтын байгууллага	5
2. Суралцагчид, Шинээр элсэгчид, Төгсөгчид	5
3. Ажиллагчид, үндсэн багш	9
4. Зарим үндсэн үзүүлэлтийн олон улсын харьцуулалт	11

Танилцуулгыг хянасан:

О.Дүнжиннамдаг БШУЯ-ны Мэдээллийн технологи, статистикийн хэлтсийн
дарга

Танилцуулгыг боловсруулсан:

Д.Анхзаяа БШУЯ-ны Мэдээллийн технологи, статистикийн хэлтсийн ахлах
мэргэжилтэн
И-мэйл: ankhzaya@mecs.gov.mn

Хаяг:

Засгийн газрын III байр, Бага тойруу -44, Улаанбаатар -11 Монгол Улс

Цахим хаяг: <https://meds.gov.mn/>

И-мэйл: Info@mecs.gov.mn

Утас: 11-318131

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Үзүүлэлт	2016/2017	2017/2018	2018/2019	2019/2020	2020/2021	2020/2016 Өсөлт, бууралт, %	
Их, дээд сургууль, коллеж, тоогоор	95	96	94	95	88	7.4	↓
Төрийн өмчийн	17	18	18	21	20	17.6	↑
Хувийн өмчийн	78	78	76	74	65	16.7	↓
Гадаадын их сургуулийн салбар	4	3	3	3	3	25.0	↓
Олон нийтийн/шашны өмчийн*					3	-	
Их, дээд сургууль, коллежид суралцагчид	157 138	155 248	157 625	148 446	147 293	6.3	↓
Эмэгтэй	91 526	90 094	93 552	90 574	89 463	2.3	↓
Эрэгтэй	65 612	65 154	64 073	57 872	57 830	11.9	↓
Төрийн өмчийн	91 798	89 473	87 992	82 901	76 844	16.3	↓
Хувийн өмчийн	65 340	65 775	69 633	65 545	63 545	2.7	↓
Олон нийтийн/шашны өмчийн					6 904	-	
Дипломын дээд	-	124	362	98	124	-	
Эмэгтэй	-	21	191	14	17	-	
Эрэгтэй	-	103	171	84	107	-	
Бакалавр	133 223	130 484	130 545	119 203	119 108	10.6	↓
Эмэгтэй	76 753	74 883	76 394	71 622	71 375	7.0	↓
Эрэгтэй	56 470	55 601	54 151	47 581	47 733	15.5	↓
Магистрантур	20 066	20 345	22 499	25 753	24 813	23.7	↑
Эмэгтэй	12 552	12 697	14 554	17 066	16 291	29.8	↑
Эрэгтэй	7 514	7 648	7 945	8 687	8 522	13.4	↑
Докторантур	3 849	4 295	4 219	3 392	3 248	15.6	↓
Эмэгтэй	2 221	2 493	2 413	1 871	1 780	19.9	↓
Эрэгтэй	1 628	1 802	1 806	1 521	1 468	9.8	↓
Эрэгтэй-эмэгтэй суралцагчдын тооны харьцаа	72	72	68	64	65	9.7	↓
Их, дээд сургууль, коллежид шинээр элсэгчид	41 195	45 480	44 094	17 566	25 165	38.9	↓
Эмэгтэй	24 097	26 592	26 373	10 554	15 839	34.3	↓
Эрэгтэй	17 098	18 888	17 721	7 012	9 326	45.5	↓
Шинээр элсэгчдээс тухайн жилд 12 дугаар анги төгсөгчид	27 626	32 919	31 558	11 915	19 283	30.2	↓
Нийт төгсөгчид	34 681	29 164	23 038	28 045	-	-	
Эмэгтэй	21 179	17 476	13 513	17 283	-	-	
Эрэгтэй	13 502	11 688	9 525	10 762	-	-	
Төгсөгчдөөс ажлын байртай болсон	11 164	10 029	7 981	-	-	-	
Ажиллагчдын тоо	12 740	12 705	12 634	11 342	11 970	6.01	↓
Эмэгтэй	7 945	7 918	7 912	7 077	7 505	5.5	↓
Эрэгтэй	4 795	4 787	4 722	4 265	4 465	6.9	↓
Үндсэн багшийн тоо	6 917	6 724	6 668	7 330	7 143	3.3	↑
Эмэгтэй	4 130	3 997	4 028	4 491	4 314	4.5	↑
Эрэгтэй	2 787	2 727	2 640	2 839	2 829	1.5	↑


Тайлбар: Дээд боловсролын салбарын статистикийн мэдээллийн маягт 2020 онд шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор байгууллагын өмчийн хэлбэрийн ангилалд өөрчлөлт орж, олон нийтийн/шашны гэсэн ангилал нэмэгдсэн болно.

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

1. Дээд боловсролын сургалтын байгууллага

Манай улсад үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоо 2020-2021 оны хичээлийн жилд 88 байгаагийн 37 (42.1%) нь их сургууль, 45 (51.1%) нь дээд сургууль, 3 (3.4%) нь коллеж, 3 (3.4%) нь гадаадын их сургуулийн салбар байна. Үүний 65 (73.9 %) нь төрийн бус өмчийн, 20 (22.7 %) нь төрийн өмчийн, 3 (3.4%) нь олон нийтийн/шашны¹ өмчийн сургууль байна. Нийт сургуулийн 79 (89.8%) нь Улаанбаатар хотод, 9 (10.2%) хөдөө, орон нутагт байна.

Зураг 1. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо, ангиллаар, 2017-2021 он




Нийгэм, эдийн засаг хурдацтай хөгжихийн хэрээр дээд боловсролын эрэлт хэрэгцээ нэмэгддэг. Улс орны эдийн засгийн урт хугацааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд дээд боловсролд хөрөнгө оруулалт хийх нь нэн чухал юм. Тиймээс өөрийн улс оронд гадаадын нэр хүндтэй их, дээд сургуулийн салбарыг бий болгох чиглэлээр анхаарсан бодлогыг хэрэгжүүлэх нь бидний өрсөлдөх чадварт чухал нөлөөтэй.

2. Суралцагчид, Шинээр элсэгчид, төгсөгчид

Манай Улсын Их, дээд сургууль, коллежид суралцагчдын тоо 2019-2020 оны хичээлийн жилд 148.4 мянга байсан бол 2020-2021 оны хичээлийн жилд 147.3 мянга болж, өмнөх хичээлийн жилээс 1.1 (0.7%) мянгаар буурсан байна.

¹ Дээд боловсролын салбарын статистикийн мэдээллийн маягт 2020 онд шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор байгууллагын өмчийн хэлбэрийн ангилалд өөрчлөлт орж, олон нийтийн/шашны гэсэн шинэ ангилал нэмэгдсэн болно.

Зураг 2. Нийт суралцагчид, хүйсээр, 2017-2021 он



Их, дээд сургууль, коллежийн суралцагчдыг хүйсээр авч үзвэл, 2020-2021 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 89.5 (60.7 %) мянга нь эмэгтэй, 57.8 (39.3 %) мянга нь эрэгтэй байна. Эрэгтэй, эмэгтэй оюутнуудын хүйсийн харьцаа 2020-2021 оны хичээлийн жилд 100 эмэгтэй тутамд 65 эрэгтэй ногдож байна.

Нийт суралцагчдын 130.1 (88.4 %) мянга нь их сургуульд, 16.8 (11.4 %) мянга нь дээд сургуульд, 0.1 (0.1 %) мянга нь коллежид суралцаж байгаа бол 0.2 (0.2 %) мянга нь гадаадын их сургуулийн салбар сургуульд суралцагчид байна.

Их, дээд сургууль, коллежид суралцагчдыг өмчийн хэлбэрээр авч үзвэл, 2020-2021 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 76.8 (52.2%) мянга нь төрийн өмчийн, 63.5 (43.1%) мянга нь хувийн өмчийн, 6.9 (4.7%) мянга нь олон нийтийн/шашны өмчийн сургуульд суралцаж байна.

Их, дээд сургууль, коллежид суралцагчдын 138.2 мянга (93.9%) нь Улаанбаатар хотод, 9.1 мянга (6.1%) нь хөдөө, орон нутагт суралцаж байна.

Нийт суралцагчдын 134.6 (91.4%) мянга нь өдрөөр, 3.0 (2.0%) мянга нь орой, 9.7 (6.6 %) мянга нь эчнээ ангид суралцаж байна.

Их, дээд сургууль, коллежид суралцагчдыг өмчийн хэлбэрээр авч үзвэл, 2019-2020 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 55.8 хувь нь төрийн өмчийн сургуульд суралцаж байсан бол 2020-2021 оны хичээлийн жилд 52.2 хувь болж, 3.6 пунктээр буурсан байна.

Зураг 3. Нийт суралцагчид, өмчийн хэлбэрээр, 2017-2021 он



Их, дээд сургууль, коллежийн суралцагчдыг боловсролын зэргээр авч үзвэл, 2020-2021 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 119.2 мянга (80.9 %) нь бакалавр², 24.8 мянга (16.9 %) нь магистр, 3.2 мянга (2.2 %) нь докторын зэрэг эзэмшихээр суралцаж байна.


Хүснэгт 1. Нийт суралцагчид, боловсролын зэргээр, хүйсээр, 2017-2021 он

Үзүүлэлт	2017-2018	2018-2019	2019-2020	2020-2021
Бүх суралцагчид	155248	157625	148446	147293
Үүнээс: Эмэгтэй	90094	93552	90573	89463
Дипломын дээд	124	362	98	124
Үүнээс: Эмэгтэй	21	191	14	17
Бакалавр	130484	130545	119203	119108
Үүнээс: Эмэгтэй	74883	76394	71622	71375
Магистрантур	20345	22499	25753	24813
Үүнээс: Эмэгтэй	12697	14554	17066	16291
Докторантур	4295	4219	3392	3248
Үүнээс: Эмэгтэй	2493	2413	1871	1780

² Бакалаврын зэргийн суралцагчдад дипломын дээд боловсролын зэргийн суралцагчдыг оруулсан.


Шинээр элсэгчид 2019-2020 оны хичээлийн жилд 17.6 мянга байсан бол 2020-2021 оны хичээлийн жилд 25.2 мянга болж, 7.6 (43.3%) мянгаар өссөн байна. Их, дээд сургууль, коллежид 2019-2020 оны хичээлийн жилд шинээр элсэгчдийн 62.9 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг 4. Шинээр элсэгчид, хүйсээр, 2017-2021 он



Шинээр элсэгчид 2020-2021 оны хичээлийн жилд 25.2 мянга байгаагийн 15.8 (62.9%) мянга нь эмэгтэйчүүд байна.

Зураг 5. Нийт суралцагчид, аймгаар, хүйсээр, 2020-2021 оны хичээлийн жил



Их, дээд сургууль, коллежийг 2018-2019 оны хичээлийн жилд нийт 23.0 мянган оюутан төгссөн бол 2019-2020 оны хичээлийн жилд 28.1 мянга болж, 5.0 (21.7 %) мянгаар өссөн байна. 2019-2020 оны хичээлийн жилд нийт 28.1 мянган оюутан төгссөний 17.3 (61.6%) мянга нь эмэгтэйчүүд байна.


Хүснэгт 2. Нийт төгсөгчид, боловсролын зэргээр, 2016-2020 он

Үзүүлэлт	2016/2017	2017/2018	2018/2019	2019/2020
Бүх төгсөгчид	34 681	29 164	23 038	28 045
Үүнээс: Эмэгтэй	21 179	17 476	13 513	17 283
Дипломын дээд	495	45	409	268
Үүнээс: Эмэгтэй	364	17	68	96
Бакалавр	30 301	25 120	18 951	23 081
Үүнээс: Эмэгтэй	18 379	14 932	11 195	14 112
Магистр	3 772	3 868	3 574	4 531
Үүнээс: Эмэгтэй	2 374	2 446	2 185	2 959
Доктор	113	131	104	165
Үүнээс: Эмэгтэй	62	81	65	95

3. Ажиллагчид

Их, дээд сургууль, коллежийн ажиллагчдын тоо 2017-2018 оны хичээлийн жилд 12.7 мянга байсан бол 2020-2021 оны хичээлийн жилд 11.9 мянга болж, 0.7 мянга (5.8%)-аар буурсан байна. Нэг их, дээд сургууль, коллежид ногдох ажиллагчдын тоо дунджаар 136 байна. Үндсэн багшийн тоо 2017-2018 оны хичээлийн жилд нийт ажиллагчдын 52.9 хувийг эзэлж байсан бол 2020-2021 оны хичээлийн жилд 59.7 хувь болж, 6.7 пунктээр нэмэгдсэн байна.


Зураг 6. Дээд боловсролын сургалтын байгууллагад ажиллагчид, 2017-2021 он



Нийт ажиллагчдын тоог өмчийн хэлбэрээр харвал, 2020-2021 оны хичээлийн жилд нийт ажиллагчдын 63.2 хувийг төрийн өмчийн сургуулийн ажиллагчид эзэлж байсан бол үндсэн багшийн 59.9 хувь нь төрийн өмчийн сургуульд багшилж байна.

Нийт үндсэн багшийн тоог өмчийн хэлбэрээр харвал, 2020-2021 оны хичээлийн жилд 4.3 мянга (59.9 %) нь төрийн өмчийн, 2.9 мянга (40.1 %) нь хувийн өмчийн сургуульд багшилж байна.

Зураг 7. Их, дээд сургууль, коллежийн үндсэн багш, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2017-2021 он



Хүснэгт 41. Дээд боловсролын сургалтын байгууллагад ажиллагчид, 2015-2019 он


Дээд боловсролын сургалтын байгууллагад ажиллагчид	2017-2018	2018-2019	2019-2020	2020-2021
Ажиллагчдын тоо	12 705	12 634	11 306	11 970
Эмэгтэй	7 918	7 912	7 061	7 505
Эрэгтэй	4 787	4 722	4 245	4 465
Үндсэн багшийн тоо	6 724	6 669	7 315	7 143
Эмэгтэй	3 997	4 028	4 482	4 314
Эрэгтэй	2 727	2 641	2 833	2 829
Нийт ажиллагчдад үндсэн багшийн элзэх хувь	52.9	52.8	64.7	59.7

4. Зарим үндсэн үзүүлэлтийн олон улсын харьцуулалт

НҮБ-ын ЮНЕСКО-гийн статистикийн байгууллагын мэдээллээр нэг багшид ногдох оюутны тоо хамгийн бага байгаа нь Япон улс 7, Герман улс 8, Канад улс 9, ОХУ 10 байна. Харин БНСУ 14, Их Британи улс 16, Итали улс 20, Монгол Улс 23 байгаа нь хамгийн их байна. Хэрэв нэг багшид ногдох хүүхдийн тоог 15-д хүргэвэл, багшийн тоог дор хаяж 10.2 мянга болгож, 39.4 хувиар нэмэгдүүлэх шаардлага үүсэж байна.


Дээд боловсролд суралцах хугацааг 2017 оны байдлаар авч үзвэл, Турк улс 5.7 жил, Финланд 4.3 жил байгаа нь хамгийн өндөр байна. Харин хамгийн бага нь Бразил улс 2.4 жил, Их Британи улс 2.9 жил байна. Монгол Улсын хувьд дээд боловсрол эзэмшихээр суралцаж байгаа хугацаа нь 3.1 жил байна.

Зураг 126. Дээд боловсролд суралцах дундаж хугацаа, жилээр, 2017 он



Олон улсын түвшинд авч үзвэл, дээд боловсролын нийт төгсөгчдийн дийлэнх хувь нь санхүү, бизнесийн удирдлагын чиглэлээр төгссөн байна. Тухайлбал, Бразил улсад 35.6 хувь нь, Турк улсад 34.6 хувь нь, ОХУ-д 33.1 хувь нь, Монгол Улсад 24.9 хувь нь, ХБНГУ-д 23.4 хувь нь, Их Британи-д 22.0 хувь нь энэ чиглэлээр төгссөн байна.


Зураг 127. Дээд боловсролын нийт төгсөгчид, дүнд эзлэх хувиар, мэргэжлийн чиглэлээр, улсаар, 2016 он



Эх үүсвэр: Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын боловсролын тайлан

Их Британи Улсын дээд боловсролын нийт суралцагчдын 17.9 хувь нь, Австри Улсын 17.2 хувь нь, Нидерланд Улсын 11.0 хувь нь гадаад оюутан байгаа бол Монгол Улсын нийт суралцагчдын 1.0 хувь нь, Мексик, Бразил, Колумби, Индонез Улсуудад 1 хүрэхгүй хувийг гадаад оюутнууд эзэлж байна.

Зураг 128. Дээд боловсролд суралцаж буй гадаад оюутан, дүнд эзлэх хувиар, улсаар, 2017 он



Эх үүсвэр: ЮНЕСКО-гийн Статистикийн институт